

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ

ХОРООНЫ ТОГТООЛ

2008 оны 12 дугаар
сарын 17-ны өдөр

Дугаар 288

Улаанбаатар хот

“Батжин нэгдэх үрс” ХХК-д валют солих цэг
ажиллуулах зөвшөөрөл олгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, Санхүүгийн зохицуулах хорооны 2008 оны 91 дүгээр тогтоолоор батлагдсан “Валют солих цэг ажиллуулах журам”-ын 5.2, 5.3 дахь тус тус заалтыг үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Батжин нэгдэх үрс” ХХК-д валют солих цэг ажиллуулах зөвшөөрлийг олгосугай.
2. Хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ чанд биелүүлж ажиллахыг “Батжин нэгдэх үрс” ХХК /Ж.Батням/-д үүрэг болгосугай.
3. Тогтоолын биелэлтэд тогтмол хяналт тавьж ажиллахыг Бичил санхүүгийн газар /Н.Оюунчимэг/-т, олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /Н.Удаанжаргал/-т тус тус даалгасугай.

ДАРГА

Д. БАЯРСАЙХАН

Хуулбар үнэн:
АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА

О.ГАНБАТ